



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/52

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Өрсөлдөөний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллуулсан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2021 оны 01, 02 дугаар сарын цалингийн зардалд 1,592,540 (нэг сая таван зуун өрэн хоёр мянга таван зуун дөч) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх албан хаагчийн цалингийн зардал 1,592,540 (нэг сая таван зуун өрэн хоёр мянга таван зуун дөч) төгрөгийг Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100116